

Хүүхдийн клиник сувилал №4

Эрхэм зорилго "Эрүүл хүүхэд эх орны ирээдүй"

- Архаг суурь өвчтэй 5 хүртэлх насны хүүхдүүдийг амийг бус эмчилгээний аргаар сувилан эрүүлжүүлж, эмчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг сайжруулах

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөж, чанар хүртээмжийг сайжруулна

- Хангалттай идэвхтэй хүн хүчний нөөцөд тулгуурлан шинэ санаа, шинэтеник, технологийг судалж эмчилгээ, сувилгааны үр дүнтэй хэлбэрийг нэвтрүүлэх

- Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, санхүү аж ахуйн үйл ажиллагааг хэвийн явуулахад нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглах,

- Нутаг дэвсгэрийн 5 хүртэлх насны хүүхдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, салбарын шинэ техник, технологийг ашиглан ижил үйл ажиллагаатай бусад сувиллуудтай өрсөлдөх чадвартай, өрсөлдөхөд бэлэн байж, байгууллагаа хөгжүүлнэ.

Түүхэн зурвас: 1934 онд эсгий, цэмбэний фабрикийн дэргэд 8 ортой, 3 ажилчинтай хүүхэд асрах нэртэйгээр байгуулагдсан.

1940 онд 30 ортой болж өргөжсөн.

1957 онд одоогийн барилга ашиглалтад орж 50 ороор, хүүхэд асрах ясли нэртэйгээр ажиллаж эхэлсэн.

1965 онд 75 ортой, 24 цагийн ажиллагаатай болсон

1974 онд 120 ортой

1991 онд Улаанбаатар хотын АДХГЗ-ны ЭХЯ-ны 1991 оны А/39,83 тоот тогтоол, тушаалаар 1-3 насны архаг суурь өвчтэй хүүхдүүдийг хүлээн авдаг сувиллын ясли

2001 онд Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг даргын 2001 оны 98/197 тоот хамтарсан захирамж, тушаалаар хүүхдийн клиник сувилал болон өргөжиж,

Дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, нутаг дэвсгэрийн нэгдсэн эмнэлэг, амбулатори, өрхийн эмнэлгүүдээс илгээсэн 5 хүртэлх насны архаг суурь өвчтэй бялдрын өсөлт хөгжил, биеийн ерөнхий чадав хийг сэргээх, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх тусламж үйлчилгээ үзүүлдэг.

Бүтэц зохион байгуулалт:

Захиргаа ерөнхий эмч, Захиргаа аж ахуй, Эмчилгээний тасаг, санхүү, гал тогоо, угаалга, 5 хэсэгтэй

Үйл ажиллагаа:

Тус хүүхдийн клиник сувилал нь 1-3 насны архаг суурь өвчтэй хүүхдүүдэд нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэх, үндсэн үйл ажиллагаа явуулдаг, 110 ортой 24 цагийн үйл ажиллагаатай, эмчилгээний 3 кабинет ажилладаг.

Эмчилгээнд:

Эмчилгээний хоол

Утлага

Бумба, гич тавих

Төөнүүр

Төрөл бүрийн масс аж, доргион масс аж

Шарлага эмчилгээ

Бие бялдрыг хөгжүүлэх хөдөлгөөний а-2 дасгалууд

Усан эмчилгээ /таван рашаан, шилмүүст рашаан, барагшуунтв рашаануудад оруулах, давстай хар цай,ясны шөл, шар усанд оруулах/

Усан бассейнд оруулах

Хүчилтөрөгчийн коктейл эмчилгээ

Витаминжуулалт

Хүүхдийг насаар нь хүүхэд хөгжүүлэх сургалтад хамруулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

1998 оноос хүүхэд чийрэгжүүлэх кабинетыг нээн ажиглуулснаар хүүхдийн өвчлөл буурч, тураалтай хүүхдийн жингийн нөхөлт сайжирч, чийрэгжилтийн чанарын үзүүлэлт 98%-д хүрсэн.

1999 оноос хүчилтөрөгчийн коктейль эмчилгээг явуулж эхэлсэнб

2001 оноос Монгол хүүхдийн стандарт

2002 "Хүүхдийн өвчний цогц менежмент"-гийг эмчилгээний стандарт

2002 оноос "Хүүхдийн бие бялдрын хөгжлийг тодорхойлох үзүүлэлт

2003 оноос "Монгол хүүхдийн мэдрэл сэтгэцийн хэвийн байдал" зэрэг үзүүлэлт, стандартыг мөрдөн үр дүнг нь тооцон ажиллаж байна.

Төрийн ба төрийн бус байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар хамтран ажиллаж байна. Үүнд Дезрит Энэрэл ОУБайгууллага, Английн хүүхдийг ивээх

сан, Швейцар ийн хөгжлийн агентлаг, 2007 оноос Дэлхийн Зөн ОУБ-тай хамтран ажиллаж байна.

Хэрэгжсэн төсөл:

Дезерит Энэрэл Олон Улсын байгууллага

- 2001.07 сар "Хүүхдийн өсөн торних эрүүл таатай орчин бүрдүүлэх" төслөөр хүүхдийн ор 50ш, хүүхдийн ор хөнжлийн даавуу 125ш, матраас, матрасны уут 50ш, бүгд 1850000 төг

- 2003 оны 07 сар "Хүүхдийн хоол тэжээлийг дэмжих" төслөөр гал тогооны тоног төхөөрөмж засуулахад 605350 төг

- 2003 оны 11 сар "Хүүхдийн хоол тэжээлийг дэмжих" төслөөр гал тогооны тоног төхөөрөмж засуулахад.

- 2006. 09 сар "Гадна суваг болон дотор сантехникийн хэсэгчилсэн засвар" 1653500 төгрөгийн өртөгтэй төсөл

Английн хүүхдийн ивээх сан

- 2004 он "Хүүхдийн ор шинэчлэл" төсөл хүүхдийн 110 орны тавцан шинээр засуулсан. 607000 төг